




ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН
2021







ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



Мэндчилгээ



Эрхэм хүндэт Нийтийн аж ахуйн салбарын нийт ажилтан, албан хаагчид, мэргэжил нэгт нөхөд, бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж, хамтран ажилладаг байгууллагууд, хэрэглэгч Та бүхэндээ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааныхаа тайланг өргөн барьж байна.

Зохицуулах зөвлөл нь 2021 онд хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд нийтийн аж ахуйн салбарын хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулалт, тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өртөг, зардлыг бууруулж, үр өгөөжийг дээшлүүлэх, хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, салбарын үйл ажиллагаа болон усны зөв зохистой хэрэглээний талаар олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр ихээхэн үр дүнтэй ажиллаа.

Монгол Улсын “Алсын хараа 2050”, “Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын дагуу Монгол Улсын иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд ус хангамж, ариун цэврийн асуудлуудыг нь шийдвэрлэхээр шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган, Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Хүн амын унд ахуйн усны чанарт тавих хяналтыг сайжруулж, ундны усны стандартын шаардлага хангасан усаар хүн амыг хангах ажлын хүрээнд Зохицуулах зөвлөлөөс ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, Хими-химийн технологийн хүрээлэнтэй тус тус хамтран олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байгаа билээ. Үүнээс дурдвал, 2021 оны байдлаар Төв, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь аймгууд болон Төмөр замын дагуух төв, суурин газруудын ундны усны нийт гүний худгуудад усны чанарын судалгаа хийж, мэдээллийн сан байгууллаа.

Сүүлийн жилүүдэд дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахал гарч, хүн бүрийн хувийн ариун цэвэр, сахилга бат, нийгмийн оролцоог шаардсан, улс орнуудын хамтын ажиллагаа, системтэй зохион байгуулалтад дүгнэлт гаргасан нэн хариуцлагатай жилүүд болж өнгөрлөө. Нөгөө талаас цар тахалтай тэмцэж буй эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шийдлүүд нь биднийг шинэ нөхцөлд дасан зохицох, амьдралын хэв маяг, дадал хандлагыг өөрчилж, өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, уулзалт, албан ажлуудыг цахим хэлбэрт шилжүүлэхэд ихээхэн түлхэц болж байна.

Цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн нөхцөл байдалд дэмжлэг үзүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12-р сарын 13-ны өдрийн 211 тоот тогтоолоор айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах тухай шийдвэрийн дагуу нийт 728.1 мянган айл өрх, 27.8 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг тус хөнгөлөлтөд хамрууллаа.

2022 оны хувьд салбарын байгууллагууд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээгээ илүү сайжруулж, хүн амыг стандартын шаардлага хангасан цэвэр усаар ханган, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг тасралтгүй, найдвартай хүртээмжтэй хүргэх ажлыг өргөжүүлэн, ард иргэдийнхээ тав тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллах сайхан жил болно гэдэгт итгэлтэй байна.

Нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан, Зохицуулах зөвлөлтэй хамтран ажилладаг та бүхэндээ байгууллагынхаа нэрийн өмнөөс таларх илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

 Ж.БАТСУУРЬ



ОРШИЛ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар Зохицуулах Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуурга /цаашид "УХАТ" гэх/-ын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Зохицуулах Зөвлөл Монгол Улсад УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчдэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.



Алсын хараа

Тогтвортой хөгжлийг хангах усны үйлчилгээг ухаалаг, уян хатан зохицуулагч манлайлах байгууллага байна.



Эрхэм зорилго

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхүйц, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй усны үйлчилгээг үр өгөөжтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

1

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Усны үйлчилгээг хэрэглэгчид шударгаар, тэгш хүртэх боломжийг хангах;

2

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Усны үйлчилгээний давамгай байдалд үр дүнг чухалчилсан зохицуулалт хийх;

3

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Хангагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;

4

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх;

5

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн манлайлагч байгууллага болох

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Үнэ, тарифын чиглэлээр


- 1.1** Хуулийн 10.1.1 дэх заалт буюу цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд:
- 1.1.1 Монгол Улсын 21 аймгийн сумдын ус түгээх байрны судалгааг хийж, нэгтгэн гаргав.



- 1.1.2 Дараах 24 тусгай зөвшөөрөл эзэмшигч, суурин газруудын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, Хууль, зүй дотоод хэргийн яамны улсын бүртгэлд бүртгүүлэхээр материалыг явуулав. Үүнд:

- ✓ УБ хот, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ;
- ✓ “Багануур ус” ОНӨААТҮГ;
- ✓ “Чандмань Налайх” ОНӨААТҮГ;
- ✓ “Дархан ус суваг” ХК;
- ✓ “Чандмань Баянхонгор” ХК;
- ✓ “Төв чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ;

- ✓ “Онги Ус суваг” ОНӨААТҮГ;
- ✓ “УС ДУ” ОНӨААТҮГ;
- ✓ “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ;
- ✓ “Булган мээж” ХХК;
- ✓ “Дундговь-Ус” ОНӨААТҮГ;
- ✓ “Хөвсгөл ус суваг” ХХК;
- ✓ УБТЗ-ын ЭХУХ-ийн 1,2-р анги;
- ✓ БАҮ-ны 1,2,3-р анги;
- ✓ “СУАТ” ХХК;
- ✓ “Гавшгай ус” ХХК;
- ✓ “Ундарга-Алтай” ААТҮГ;
- ✓ “Чандмань-Увс” ХХК;
- ✓ “Шим-ус” ОНӨААТҮГ;
- ✓ “Гүний-Ус” ХХК;
- ✓ Ховд аймгийн Зэрэг сум;
- ✓ Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум;
- ✓ Өмнөговь аймгийн 11 сум;
- ✓ Булган аймгийн Рашаант сум






1.1.3 2021 онд доорх 10 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн бөөний болон дамжин тарифын саналыг хянаж борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг баталсан. Үүнд:

- ✓ “Нарантуул илч” ХХК, /БОШ-г батлахаа хойшлуулсан/;
- ✓ “Эрчим скай стар” ХХК;
- ✓ “Оч гялс өргөө” ХХК;
- ✓ “Ариг гал” ХК /ТЗ-гүй/;
- ✓ БАУ-ны 1,2,3-р анги;
- ✓ “Тохилог шинэ ертөнц” ХХК;
- ✓ “Биг кастел” ХХК;
- ✓ “Смарт план” ХХК;
- ✓ “Аж богд инженеринг” ХХК;
- ✓ Тусгай зориулалтын машинаар бохир ус татан зайлуулдаг тусгай зай зөвшөөрөл эзэмшигчид;
- ✓ Улаанбаатар хотын зарим хувийн хэвшлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид.



1.1.4 Улсын 21 аймгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифын ялгааг тодорхойлох, цаашид авч хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох судалгааг хийсэн.



- 1.1.5 Зохицуулах зөвлөлийн 2018 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлал”-д нэмэлт өөрчлөлт оруулж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.
- 1.1.6 Зарим аймаг, сумын төвийн зөөврийн цэвэр, бохир усны тарифыг баталсан.
- 1.1.7 Тусгай зориулалтын машинаар бохир ус татан зайлуулдаг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жишиг тарифыг батлав.
- 1.2** Хуулийн 10.1.2 дахь заалт буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох ажлын хүрээнд: Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгуулагуудын 2020 оны элэгдлийн тайланг гаргаж, нэгтгэв. 2021 онд тарифын санал ирүүлсэн 37 байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг бүртгэсэн. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифын өртгөө нөхөх түвшинг тодорхойлж бүртгэл хөтлөв.



ТАРИФ, ТООЦОО СУДАЛГАА



Тусгай зөвшөөрлийн чиглэлээр

1.3 Хуулийн 10.1.3 дахь заалт буюу Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд:

1.3.1 1.3.1. Орон нутгийн НАА-н дараах 20 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг Зохицуулах зөвлөлийн 2021 оны хуралдаанаар хэлэлцүүлэн баталж, Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг 3-5 жилийн хугацаатай тус тус сунгалаа. Үүнд:

- ✓ Өмнөговь аймгийн төвийн “Гүний-Ус” ХХК;
- ✓ Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Мандал-Энерго” ОНӨААТҮГ;
- ✓ Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмтнаран” ОНӨААТҮГ;
- ✓ Говьсүмбэр аймгийн төвийн “Ус-Ду” ОНӨААТҮГ;
- ✓ Говьсүмбэр аймгийн Шивээ-Овоо сумын “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ;
- ✓ Увс аймгийн “Чандмань-Увс” ХХК;
- ✓ Сэлэнгэ аймгийн Сайхан сумын “Гавшгай ус” ХХК;
- ✓ Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын ус хангамжийн үйлчилгээг хариуцдаг “Монголросцветмет” ТӨҮГ;
- ✓ Баян-Өлгий аймгийн төвийн «СУАТ» ХХК;
- ✓ Завхан аймгийн төвийн «Амь-Ус» ХХК;
- ✓ Сэлэнгэ аймгийн төвийн НААУ-ний “Урсгал-Ус” ХХК;

- ✓ Хэнтий аймгийн төвийн “Хэнтий-Ус” ХХК;
- ✓ Төв аймгийн төвийн Төв Чандмань ДЭХГ» ОНӨААТҮГ;
- ✓ Завхан аймгийн Тосонцэнгэл сумын НААҮ-ний «Тосон Очирт хайрхан» ОНӨААТҮГ;
- ✓ “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн “ЭХУХ”-ийн төв;
- ✓ Сэлэнгэ аймгийн Мандал сумын НААҮ-ний «Цант-Орхон» ОНӨААТҮГ;
- ✓ « Улаанбаатар төмөр зам « ХНН-ийн Барилга ашиглалт үйлчилгээний 1, 2, 3-р ангиуд;
- ✓ Улаанбаатар хотын “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ;
- ✓ Багануур дүүргийн “Багануур-Ус” ААТҮГ;
- ✓ Дархан-Уул аймгийн “Дулаан шарын гол” ТӨХК.



1.3.2 Улаанбаатар хотын ОСНААҮ-ний дараах 23 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай тус тус сунгалаа. Үүнд:

- | | |
|---------------------------------------|-------------------------|
| ✓ “Бьюлдинг мэйнтэнэнс сервисэс” ХХК; | ✓ “Батбаян дулаан” ХХК; |
| ✓ “УНК” ХХК; | ✓ “Хайспийд групп” ХХК; |
| ✓ “Грийт лакс” ХХК; | ✓ “Өөдөө байгаль” ХХК; |
| ✓ “Батзохиомж” ХХК; | ✓ “Хүннү хотхон” ХХК; |
| ✓ “Морьттүнгэ” ХХК; | ✓ “Хайспийд групп” ХХК; |
| ✓ “Дунд мандал” ХХК; | ✓ “Монтс” ХХК; |
| ✓ “Жинст-Өргөө” ХХК; | ✓ “Арга мэргэн” ХХК; |
| ✓ “Аж богд инженеринг” ХХК; | ✓ “Таван-Өндөр” ХХК; |
| ✓ “Трю эл менежмент” ХХК; | ✓ “Булнай-Ар” ХХК; |
| ✓ “Голд компас” ХХК; | ✓ “Санкомфорт” ХХК; |
| ✓ “Комфорт Монгол нэтворк” ХХК; | ✓ “Гангар-Орд” ХХК; |
| | ✓ “Эрин барилга” ХХК. |



1.3.3 Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, туршилт, тохируулгын, бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхлэх болон энэ чиглэлээр ангилал нэмүүлэх хүсэлт ирүүлсэн дараах 14 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах, ангилал нэмэх асуудлыг шийдвэрлэж, Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай тус тус сунгаж, мөн ангилал нэмлээ. Үүнд:

- | | |
|---|--------------------------------|
| ✓ “Эгц шугам” ХХК; | ✓ “Оч гялс өргөө” ХХК; |
| ✓ “Зуслан сэрвэн цохио” ХХК; | ✓ “Хаанзаа сервис” ХХК; |
| ✓ “Марззүрх хайрхан” ХХК; | ✓ “Тасган эрдэнэ” ХХК; |
| ✓ “Баянбулаг Баянзүрх” ХХК; | ✓ “Маргад эрдэнэ” ХХК; |
| ✓ Налайх дүүргийн НААҮ-ний
“Чандмань Налайх” ОНӨААТҮГ; | ✓ “Ерөөл ус” ХХК; |
| ✓ “Хайспийд” ХХК; | ✓ “Ай Вай И Зэт групп” ХХК; |
| ✓ “Сод эгшиг” ХХК; | ✓ “Өгөөмөр дэлгэр ширээт” ХХК. |

1.3.4 Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах хүсэлт ирүүлсэн дараах 14 аж ахуйн нэгж, байгууллагуудын асуудлыг Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн батлуулж, 3 жилийн хугацаатай тус тус олголоо. Үүнд:

- ✓ Хөвсгөл аймгийн “Эв УХАТ” ХХК /УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга/;
- ✓ Улаанбаатар хотын “Нарантуул Илч” ХХК /ОСНААҮ-ний чиглэл/;
- ✓ “Эрчим скай стар” ХХК /ОСНААҮ-ний чиглэл/;
- ✓ “Томмасс” ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- ✓ Сэлэнгэ аймгийн Мандал сумын ШШГХ-413-р анги /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- ✓ “Юу Би энд Э Би Тур» ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар

- зөөвөрлөх үйлчилгээ/;
- ✓ “Эс Энд Эй трейд” ХХК /бохир ус цэвэрлэх байгууламж барьж, байгуулах/;
- ✓ “Ханжин ложистик” ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- ✓ “Хашын хишигтэн» ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- ✓ Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НААҮ-ний “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ /Орон нутгийн Нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх үйлчилгээ/;
- ✓ “Гант ус байгаль” ХХК /УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ/;
- ✓ “Шинэ өргөө дэвжих трейд” ХХК /бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээ/;
- ✓ «Төгс байшин констракшн» ХХК /цэвэрлэх байгууламж барьж, байгуулах/;
- ✓ “Алтайн экос” ХХК /цэвэрлэх байгууламж барьж, байгуулах/.

1.3.5 Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НААҮ-ний “Чандмань бадрал” ХХК-ийн



Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүсэлтийн дагуу Зохицуулах зөвлөлийн 9 дүгээр сарын хуралдаанаар хэлэлцэн, шийдвэрлэв.

Тайлант хугацаанд сунгуулах 52, тусгай зөвшөөрлийн ангилал шинээр нэмүүлэх 5, тусгай зөвшөөрөл хүчингүй болгох 1, шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 14, нийт 72 материалыг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд хянан шалгаж шийдвэрлэв. Мөн Зохицуулах зөвлөлөөс гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврыг тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээнд тусган, баталгаажуулав.




Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл сунгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын 44%-ийг Улаанбаатар хотод орон сууцны цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр, 14%-ийг бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр, 38%-ийг орон нутгийн УХАТ-ын чиглэлээр, 4%-ийг цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ болон УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх чиглэлээр тус тус эзэлж байна.

Шинээр тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан болон ангилал нэмсэн асуудлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

№	Тусгай зөвшөөрлийн нэр, төрөл	Шинээр олгосон	Сунгасан	Ангилал нэмүүлсэн	Хүчингүй болсон
1	Орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам, сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	2	23		
2	Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр	1	20		1
3	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр	6	7	5	
4	Цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, байгуулах чиглэлээр	3			
5	Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ болон УХАТ-ын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх	2	2		
Нийт		5	14	52	5



Дээрх хүснэгтийг графикаар харуулбал:

График 1. Тусгай зөвшөөрлийг шийдвэрлэсэн байдал:

- Сунгасан
- Шинээр олгосон
- Ангилал нэмүүлсэн
- Хүчингүй болсон

1.4 Хуулийн 10.1.4 заалт буюу Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах:

1.4.1 Тусгай зөвшөөрөл сунгуулах болон шинээр авахаар хүсэлт ирүүлсэн Улаанбаатар хотын болон Орон нутгийн 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа нь УХАТ-ын нөхцөл, шаардлага хангаж буй эсэхийг газар дээр нь шалгаж, үнэлгээ, дүгнэлт хийж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөв.



1.4.2 Тусгай зөвшөөрлийн материалыг шалгах хуудсыг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагатай уялдуулан шинэчлэв.



1.4.3 Төв аймгийн «Төв Чандмань ДЭХГ» ОНӨААТҮГ, Дархан-Уул аймгийн «Дархан-Ус суваг» ХК, Орхон аймгийн «Эрдэнэт Үйлдвэр» ТӨХК, «Эрдэнэт-Ус ДТС» ОНӨХК, Булган аймгийн «Булган мээж» ХХК, Өвөрхангай аймгийн «Хархорин Ус суваг» ОНӨААТҮГ, «Онги ус суваг» ОНӨААТҮГ, Говь-Алтай аймгийн «Ундрага-Алтай» ОНӨААТҮГ, Баянхонгор аймгийн «Чандмань Баянхонгор» ХК, Говьсүмбэр аймгийн «Ус-Ду» ОНӨААТҮГ, «Илчлэг шивээ» ОНӨААТҮГ, «Талын илч» ОНӨААТҮГ, Дорноговь аймгийн Сайншанд сумын «Чандмань Илч» ОНӨХК, Замын-Үүд сумын «Чандмань бадрал» ХХК, Сэлэнгэ аймгийн «Сэлэнгэ цэнгэг ус» ОНӨААТҮГ, Сэлэнгэ аймгийн Мандал сумын «Цант орхон» ОНӨААТҮГ, «Мандал энерго» ОНӨААТҮГ, «Спирт бал бурам» ХХК, «УБТЗ ХНН»-ийн Төмөр замын барилга орон сууцны 1-р анги зэрэг нийт 19 байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу газар дээр нь хянаж, үнэлэлт дүгнэлт өгөв.



1.4.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн 2020 оны тайлан мэдээ, гэрээний биелэлтийг “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг дүгнэх журам”-ын дагуу үнэлэн, орон нутгийн болон Улаанбаатар хотын нийт 129 байгууллагуудад холбогдох үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлэв.



1.4.5 Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2020 оны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нэгтгэн үнэлж, 2021 оны зорилтот түвшинг тодорхойлон, албан бичгээр нийт 130 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад хүргүүлэв.



- 1.4.6 Нийслэлийн хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангуулах үүднээс Улаанбаатар хотын ундны усны бие даасан эх үүсвэрийн ашиглалтыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-т хариуцуулах асуудлыг шийдвэрлэхээр 2021 оны 10-р сарын 26-ны өдрийн 01/524 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, НИТХ-ын дарга Ж.Батбаясгалан нарт тус тус хүргүүлэв.



- 1.4.7 Үйлчлэх хүрээнд нэмэлт оруулахаар хүсэлт ирүүлсэн “Хүрд” ХХК, “Тохилог шинэ ертөнц” ХХК, “Грийтлакс” ХХК, “Баянмонгол хотхон” ХХК, “КСИМС” ХХК, “Баатардулаан хан” ХХК, “Баганат харш” ХХК, “Батбаян дулаан” ХХК, “Баян Монгол хотхон” ХХК, “Булнайн-Ар” ХХК, “Ган-Инженеринг” ХХК “Грийн проперти” ХХК зэрэг давхардсан тоогоор нийт 60 гаруй аж ахуйн нэгж, байгууллага дээр очиж ажиллан, шугам сүлжээний тодруулгыг хийн, бүртгэлийн асуудлыг шийдвэрлэв. 2021 оны эхний хагас жилд нийт 66 орон сууцны барилга, 12962 айл өрх, 225 аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хийсэн.
- 1.4.8 ХААИС-ийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид газар дээр нь хяналт шалгалт хийж, тайланг боловсруулан гаргав.



1.4.9 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, тайлан, мэдээ, гэрээний биелэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлан, мэдээг нэгтгэв.



1.4.10 Зөвлөлийн даргын 2021.06.10-ны өдрийн А/22 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгийг Налайх дүүргийн “Чандмань-Налайх” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, алдагдалтай ажиллаж буй салбар, нэгжүүдийн үйл ажиллагааны алдагдлыг бууруулах, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-т үүсгэсэн хуримтлагдсан өр төлбөрийг НИТХ-аар хэлэлцүүлэх талаар зөвлөмж боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэв. Мөн Налайх дүүргийн ИТХ, Нийслэлийн ЗД, ИТХ-ын даргад тус дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-т дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 01/368 тоот албан бичгээр хүргүүлсэн. Энэ ажлын үр дүнд 2021 оны 8-р сард Нийслэлийн ЗД-ын зөвлөлийн хурлаар уг асуудлыг хэлэлцэн, НИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барих бэлтгэл ажлыг хангахыг үүрэг болгов.

1.4.11 Нийслэлийн хэмжээнд 693 бие даасан гүний худаг байгаагаас өөрийн хэрэгцээнд 399, бусдад түгээж, борлуулдаг 304 гүний худгийн судалгааг дүүрэг тус бүрээр нэгтгэн гаргав.




1.4.12 Бохир ус зөөвөрлөдөг 60 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэрэглэгчийн судалгааг нэгтгэн гаргав. Мөн бохир ус зөөвөрлөдөг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшдэг машины дугаар, маркын судалгааг, Улаанбаатар хотын бохир ус зөөврийн автомашины зах зээлийн судалгааг тус тус нэгтгэн гаргав. Энэ ажлын үр дүнд бохир ус соруулах үйлчилгээний тусгай зөвшөөрөл шинээр олгох, энэ үйлчилгээний хамрах цар хүрээг тодорхойлох суурь мэдээлэл, судалгаатай болсон.



1.4.13 Аймаг, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын танилцуулга, мэдээллийг бэлдэн, тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт хүргүүлэв.




- 1.4.14 “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-тай гэрээтэй тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй 148 хэрэглэгчдийн судалгааг гарган, тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэхгүй байгаа шалтгаан нөхцөлыг судлав.
- 1.4.15 Хэрэглэгчдээс ирсэн гомдлын дагуу “Тохилог Шинэ Ертөнц” ХХК, “Тунгалаг буянт дуут” ХХК, “Смарт план” ХХК, “Монхауз” ХХК, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын ХҮТ-10-ын үйл ажиллагааг газар дээр нь очиж шалган, гомдлыг тухай бүр шийдвэрлэв. Мөн иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын дагуу “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-тай хамтарч “Ди Ди прогресс” ХХК-нд очиж хяналт шалгалт хийж, усны дээж авахад хэрэглээний халуун устай холбоотой зэвтэй уснаас асуудал үүссэн болох нь шинжилгээгээр гарсан тул ЭХЗХ-д хандах талаар зөвлөгөө өгөв.



- 1.4.16 “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-т “СӨХ-ны үйл ажиллагааг зогсоох, давхар хариуцахгүй байх” тухай шаардлагыг 2021.09.01-ний өдрийн 01/433 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- 1.4.17 Төв аймгийн “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ, Дархан-Уул аймгийн “Дархан-Ус суваг” ХК, Орхон аймгийн “Эрдэнэт Үйлдвэр” ТӨХК, “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, Булган аймгийн “Булган мээж” ХХК, Өвөрхангай аймгийн “Хархорин Ус суваг” ОНӨААТҮГ, “Онги ус суваг” ОНӨААТҮГ, Говь-Алтай аймгийн “Ундрага-Алтай” ОНӨААТҮГ, Баянхонгор аймгийн “Чандмань Баянхонгор” ХК, Говьсүмбэр аймгийн “Ус-Ду” ОНӨААТҮГ, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ, “Талын илч” ОНӨААТҮГ, Дорноговь аймгийн Сайншанд сумын “Чандмань Илч” ОНӨХК, Замын-Үүд сумын “Чандмань бадрал” ХХК, Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ, Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Цант орхон” ОНӨААТҮГ, “Мандал энерго” ОНӨААТҮГ, “Спирт бал бурам” ХХК, “УБТЗ ХНН”-ийн Төмөр замын барилга орон сууцны 1-р анги зэрэг нийт 19 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах ажлын хүрээнд газар дээр нь очиж ажиллав.

1.4.18 “Дархан-Ус суваг” ХК-ийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн харуул хамгаалалт, түүнтэй холбоотой санхүүжилтийн талаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зөвлөмж боловсруулан тус компанид хүргүүлэв.



1.4.19 Сангийн Яаманд Өмнөговь аймгийн “Гүний Ус” ХХК-ийн өмчийн бүртгэлийн талаар 2021.09.01-нд 01/438 тоот албан бичиг хүргүүлсэн.

1.4.20 ШӨХТГ-ын дарга Б.Бат-Эрдэнэд 2021.07.29-ний 01/376 тоотой тусгай зөвшөөрлийн төрөл, олгох үндэслэл болон бусад мэдээллийг хүргүүлсэн.

1.5 Хуулийн 10.1.5 заалт буюу Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 41 гомдол, маргааныг судалж, шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулж, холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчид үүрэг, даалгаврыг өгч, гомдол, маргааныг шийдвэрлэсэн. Үүнд:

1.5.1 “Зайсан РГВ” СӨХ-оос ирсэн “Эрчим скай стар” ХХК-тай холбоотой гомдлын дагуу газар дээр нь нөхцөл байдалтай танилцаж, хэрэглэгчийн хэрэгцээний халуун усны шугам дээр тавьсан шүүлтүүр гэмтсэн байсныг тодорхойлж, халаалт, халуун устай холбоотой гомдлыг Эрчим хүчний зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэхийг тус СӨХ-нд мэдэгдэв.







- 1.5.2 ХААИС нь ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй үйлдэлд хяналт шалгалт хийж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.




- 1.5.3 “Цэнгэлдэх ОСНААК” ХХК-ийн хэрэглэгчдийн ирүүлсэн гомдлын дагуу 2021 оны 02 дугаар сарын 04-нд “Цэнгэлдэх ОСНААК” ХХК-д улсын байцаагчийн хяналт шалгалт хийж хэрэглэгчийн гомдлыг барагдуулах албан даалгавар хүргүүлж, биелэлтийг хянаж ажиллав.
- 1.5.4 “Пюрхаус” ХХК болон хэрэглэгч хооронд үүссэн төлбөр тооцоотой холбоотой маргааныг шийдвэрлэв.
- 1.5.5 Иргэн Г.Цолмонбаатараас ирүүлсэн төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрт хамрагдах хүсэлтийг шалгаж, хангагч байгууллагатай холбогдон шийдвэрлэв.
- 1.5.6 “Цант орхон” ХХК болон УБТЗ-ын БАҮ-ний 1-р ангитай холбоотой үүсэн бохир усны төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэж, албан бичгээр хариу хүргүүлсэн.
- 1.5.7 Хан-Уул дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байх “Очгялс өргөө” ХХК-ийн хариуцдаг Англи сургуулийн багш, ажилчдын 48 айлын орон сууцны бохир усны насос нь шатсантай холбоотой асуудлаар уг насосны станцад бохир ус нийлүүлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч “Хайспийд” ХХК, “Арга мэргэн” ХХК, “Ди ди прогресс” ХХК, “Очгялс өргөө” ХХК, “ХҮТ-10” болон “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын Инженер, техникийн ажилтнуудтай хамтарсан онлайн хурал зохион байгуулж, үүрэг даалгавар өгөв.
- 1.5.8 Түмэн наяд хайрхан” ХХК болон захиалагч компанийн хооронд орон сууц ашиглалт хариуцсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийг өөрчлөх тухай маргаан гарсан тул газар дээр нь очиж шалгалт хийж, сонсох ажиллагаа зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.



- 1.5.9 “Опенхаус ӨНӨ” ХХК-ийн хэрэглэгчийн гомдлын дагуу тайлбар авч, хариуг өгч, шийдвэрлэв.
- 1.5.10 Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны 104/а байрны хэрэглэгчдийн гомдлын дагуу “Ариун очир” ХХК-д төрөөс цэвэр бохир усны төлбөрийг хариуцах хугацаанд хэрэглэгчдээс нэхэмжлэхгүй байх талаар албан шаардлагыг хүргүүлэв.




- 1.5.11 Орхон аймгийн “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-аас ирүүлсэн нэмэлт ус, конденсантайн үнийн талаар ирүүлсэн хүсэлтийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороонд тайлбар хүссэн албан бичгийг 2021.05.12-ны өдрийн 01/254 тоотойр хүргүүлэв. Мөн Эрчим хүчний зохицуулах хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 2021.06.10-ны өдрийн 01/289 тоотойр хариуг хүргүүлэв.
- 1.5.12 Зохицуулах зөвлөлийн даргын 2021.06.10-ны өдрийн А/22 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Улаанбаатар хотын Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, усны алдагдлын судалгааг газар дээр нь очиж шалган, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан гаргаж хүргүүлэв.




- 1.5.13 Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэн Б.Алтантуяагаас тус суманд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй “Чандмань бадрал” ХХК-ийн хариуцдаг бохир усны шугамын худаг таггүй байгааг тус байгууллагад мэдэгдэхэд арга хэмжээ авахгүй байгаа тухай гомдол ирүүлсний дагуу “Чандмань бадрал” ХХК-ийн ерөнхий инженер С.Ганцэцэгт мэдэгдэж, зориулалтын тагаар битүүмжилж, иргэний гомдлыг барагдуулав.



1.5.14 “Мандах тулга” СӨХ-оос “Смарт план” ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой гомдол ирүүлсний дагуу хэрэглэгчийн хэрэгцээний халуун, хүйтэн усны даралт болон цэвэр, бохир усны шугамын ашиглалтын байдлыг газар дээр нь үзэж, тус СӨХ-нд 2021.11.09-ний 01/538 тоот албан бичгээр хариуг өгөв.



1.5.15 Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Э.Батмөнхөөс “Иргэдийн хүсэлтийг уламжлах тухай” албан бичиг, “Хан-Өргөө” СӨХ-оос зэвтэй ус хэрэглэдэг тухай гомдол ирүүлсний дагуу Хан-Уул дүүргийн 2-р хорооны 5, ба байрны Ус, дулаан дамжуулах төв болон хүйтэн усны түгээх шугамаас дээж авч шинжилгээнд өгсөн. Шинжилгээний дүн мэдээгээр тус байрны хүйтэн ус нь “Ундны усны чанарын шаардлага MNS 0900-2018” стандартад нийцсэн ус хэрэглэж байгаа нь тогтоогдсон тул Хан-Уул дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Э.Батмөнх болон “Хан-Өргөө” СӨХ-нд 2021.10.14-ний 01/507 тоот албан бичгээр шинжилгээний хариуг хавсарган хүргүүлсэн.



1.5.16 Хан-Уул дүүргийн 4-р хорооны Ханбогд хорооллын оршин суугч С.Урантуяагаас тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ди ди прогресс” ХХК-ийн хариуцдаг ус, дулаан дамжуулах төвөөс зэвтэй ус байнга гардаг, зөвхөн манай Ханбогд хороолол гэлтгүй манай энэ хавийн орон сууцны хотхоны айл өрхүүд дандаа зэвтэй ус хэрэглэдэг гэсэн агуулга бүхий гомдол ирүүлсний дагуу Хан-Уул дүүргийн 4-р хороонд байрлах орон сууцны ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ди ди

прогресс” ХХК, “Шинэ Яармаг Ханбогд” ХХК-иудын хариуцдаг Ханбогд хороолол, “Арга мэргэн” ХХК-ийн хариуцдаг “Нью гарден” хотхон, “Очгялс өргөө” ХХК-ийн хариуцдаг “Хүннү вилла” хотхон, УСУГ-ын хариуцдаг Яармагийн ус хангамжийн төвлөрсөн эх үүсвэрийн уснаас дээж авч Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын лаборатори, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд өгөхөд дээрх орон сууцнуудын айл өрхүүдийн хэрэглэж буй хүйтэн ус болон Яармагийн ус хангамжийн төвлөрсөн эх үүсвэрийн хүйтэн ус нь “Ундны усны чанарын шаардлага MNS 0900-2018” стандартад нийцсэн ус болох нь тогтоогдсон. Харин хэрэгцээний халуун ус нь стандартаас давсан үзүүлэлттэй байгаа нь тогтоогдсон тул энэ талаар гомдол гаргасан иргэнд 2021.10.14-ний 01/505 тоот албан бичгээр шинжилгээний хариуг хүргүүлж, Эрчим хүчний зохицуулах хороонд ус халаагч бойлер болон халуун ус түгээх шугам сүлжээнд зөв үүсгэж байгаа тухай албан бичгийг 2021.10.14-ний 01/506 тоотоор хүргүүлсэн.



1.5.17 Орхон аймгийн “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-ийн олгосон техникийн нөхцөлтэй холбоотой “Гүн арвижих эрдэнэс” ХХК-иас ирүүлсэн гомдлыг хянаад 2021.09.30-ны 01/494 тоот албан бичгээр хариу хүргүүлэв.



1.5.18 2020 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын хэрэглэгчдээс ирүүлсэн гомдлыг нэгтгэж, судалгааг гарган БХБЯ-нд хүргүүлэв.



- 1.6** Тусгай зөвшөөрлийн журам, аргачлал, зааврыг боловсронгуй болгох, хууль, дүрэмд санал өгөх чиглэлээр:
- 1.6.1 БХБЯ-аас санал авахаар ирүүлсэн Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд холбогдох саналыг өгөв.
- 1.6.2 Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн “Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан болон иргэн, хуулийн этгээдийн хамтран эзэмших дундын шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээний зохицуулалтын журам”-д холбогдох саналыг боловсруулан хүргүүлэв.



- 1.7** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагчийн ажлын хүрээнд:
- 1.7.1 Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дэд даргын баталсан 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/170 дугаар “Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байршилтай Засгийн газрын 2 дугаар байр, Монгол Улсын Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны барилгын ашиглалтын төлөв байдалд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Барилгын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан норм ба дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд газар дээр нь үзлэг шалгалтыг хийж, ус хангамж, ариутгах татуургын нөхцөл байдалд хийсэн дүгнэлтийг гаргав.



1.7.2 Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/136 дугаартай “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байршилтай иргэн З.Пүрэв-Очирын захиалгатай “Бүти” ХХК-ийн барьж буй албан конторын зориулалттай 18 давхар барилгын төлөв байдалд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Барилгын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан норм ба дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр газар дээр нь үзлэг шалгалтыг хийж гүйцэтгээд улсын байцаагчийн дүгнэлтийг хүргүүлсэн.



1.7.3 Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн “Төлөвлөгөөт шалгалт хийх тухай” 01/113 дугаартай удирдамжийн дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Тайгам Алтай” ХХК-ийн шинээр барьж буй зочид буудал, үйлчилгээтэй 18 давхар барилгад хяналт шалгалт хийж, Улсын байцаагчийн албан шаардлага өгсөн.



2 ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХЭД ХАМААРАХ АСУУДЛААР ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВРЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ


- 2.1** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлал болон танилцуулгын төслийг боловсруулан хууль санаагчлагчид хүргүүлэв. Мөн хуулийн төслийн “Хэрэгцээ, шаардлагын судалгаа”, “Гадаад орнуудын тандан судалгаа”, “Зардлын тооцоо”, “Хэлэлцүүлэг хийсэн тайлан”-г тус тус боловсруулав.
- 2.2** Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2021 оны 02-р сарын 05-ны өдөр зохион байгуулсан Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож санал өгөв.



- 2.3** Зохицуулах зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төсвийг Засгийн газрын 2020 оны 249 дүгээр тогтоолоор баталсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн, 02 дугаар тогтоолоор Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөх зохицуулалтын үйлчилгээний хураамжийн хэмжээг тус тус батлав.

2.4 Засгийн газрын 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр:

- ✓ Аймгийн Нийтийн аж ахуйн байгууллагуудад сумдтайгаа байгуулах гэрээг цахимаар хүргүүлж, холбогдох мэдээллээр хангаж ажиллав. Үүний дагуу тус гэрээг байгуулсан судалгааг ирүүлэх маягтыг боловсруулан, сумдтай байгуулсан гэрээгээ ирүүлэх үүрэг даалгаврыг 21 аймгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд өгсөн. Тус ажлын үр дүнд нийт 21 аймгийн 330 сумаас 276 сумтай гэрээ байгуулав.




- ✓ Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч, сум суурин газрын 2020 оны 12-р сар, 2021 оны 1-12-р сарын мэдээг хянаж, тухай бүр БХБЯ-д хүргүүлсэн.
- ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төлбөрийн нэхэмжлэхийг авч, төлбөрийн шилжүүлэгийг тухай бүр хийж, санхүүжилтийг нь олгосон.





- ✓ Хэрэгжилтийн тайланг сар бүр боловсруулж, албан тоотор холбогдох газруудад тухай бүр хүргүүлж байна.
- ✓ Нийт ТЗЭ-тэй тооцоо нийлж, акт үйлдсэн.
- ✓ Төв, Баянхонгор, Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд, Дорнод, Говь-Алтай, Дархан-Уул зэрэг нийт 8 аймгийн 130 сум, Улаанбаатар хотын 9 дүүргийн 318 худаг болон УХАТ-ын судалгааг авч нэгтгэв.
- ✓ Хэрэглэгчдэд төлбөрийн мэдээлэл хүргэх тусгай дугаарыг нэвтрүүлэх, тус мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулахыг нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад даалгаж, тухайн төрөөс үзүүлж буй хөнгөлөлтийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэсэн эсэх талаар тайлан мэдээг нэгтгэн авч байна.




- ✓ Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/31 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон дунд шатны аудитын гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.
- ✓ Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааг тухай бүр тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс гаргуулан нэгтгэсэн. /НӨАТ, Дотоод хэрэглээ, хэрэглэгчтэй хийсэн тооцооны акт г.м./
- ✓ Тогтоолын хэрэгжилтийн бодит гүйцэтгэлийг гаргаж, БХБЯ-д тайлагнасан.

2.5 Орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас авах “Засгийн газрын 2019 оны 474 тогтоолын биелэлтийг авч нэгтгэх хүснэгт”-ийн загварыг боловсруулан гаргав.

2.6 Зохицуулах зөвлөлийн бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журам болон Цалин, үр дүнгийн цалингын журмыг шинэчлэн боловсруулж, батлуулав. Мөн үүнтэй холбогдуулан ажилтан, албан хаагчидтай Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулав.

2.7 Зохицуулах зөвлөлийн 2021 оны 1-11 дүгээр сарын хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж, нийт 137 тогтоол батлагдсаныг албажуулж, байгууллагын цахим мэдээллийн is.wsrc.mn болон ep.e-mongolia.mn санд байршуулав.

- 2.8** Тус Зохицуулах зөвлөлийн даргын нийт 71 тушаал /үйл ажиллагаатай холбоотой 38, боловсон хүчний 33/-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллав.
- 2.9** 2021 оны жилийн эцсийн байдлаар аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 3864 албан бичиг ирсэн бөгөөд 3637 /гүйцэтгэл 88%/, хугацаа болоогүй буюу шийдвэрлэх шатанд 227 албан бичиг байна. Мөн 590 албан бичгийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэв.



- 2.10** Иргэн, хуулийн этгээдтэй байгууллах 69 гэрээний төслийг боловсруулах, байгуулах, бүртгэх ажлыг хийв.
- 2.11** Хууль сахиулах байгууллагад байгууллагыг төлөөлөх, хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг шүүх, цагдаагийн байгууллагад гаргаж өгөх, маргаан шийдвэрлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулав. Үүнд:
 - 2.11.1 “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд тус тус оролцсон бөгөөд шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгуулж шийдвэрлүүлэв.
 - 2.11.2 “Зүмбэр орд өргөө” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх анхан шатны шүүх хуралдаанд оролцсон бөгөөд шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв.
 - 2.11.3 Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байгаа Зохицуулах зөвлөлийн дарга асан Э.Пүрэвжавт холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд төлөөлөл оролцуулсан бөгөөд шүүхээс Нийслэлийн Прокурорын байгууллагад буцааж шийдвэрлэв.
 - 2.11.4 Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021.10.08-ны өдрийн 1/2947 дагуур албан бичгийн дагуу холбогдох тайлбарыг гарган илгээв.



- 2.11.5 Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1-р хэлтсийн 2021.10.05-ны өдрийн 26к1-2/5018 дугаар албан бичгийн дагуу “Баатардулаан хан” ХХК-нд тусгай зөвшөөрөл олголттой холбоотой лавлагааг холбогдох нотлох баримтын хамт гарган, Зохицуулах зөвлөлийн 2021.10.19-ний өдрийн 01/513 дугаар албан тоотор илгээв.
- 2.11.6 Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021.10.27-ны өдрийн 3580 дугаар албан бичгийн дагуу “Батзохиомж” ХХК-нд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг бэлтгэн Зохицуулах зөвлөлийн 2021.10.29-ний өдрийн 01/526 дугаар албан тоотор илгээв.
- 2.12** Зохицуулах зөвлөлийн даргын 2021оны 06-р сарын 10-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан “Өмнөговь аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Гүний-Ус” ХХК-д Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах” ажлын хэсэг ажиллаж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэв.



ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ



3.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12-р сарын 13-ны өдрийн 211 тоот тогтоолоор айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах шийдвэр гаргасан. Тус шийдвэрийн хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар 2021 оны 01-р сарын 13-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамнаас санаачилсан Хэвлэлийн бага хуралд танилцуулав.






3.2 Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь 2021 оны 01-р сарын 13, 14-ний өдөр Ийгл, MNC, Star телевизийн мэдээний ярилцлагад цахимаар оролцож, цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах болсон шийдвэрийн хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулав.





- 3.3 Зохицуулах зөвлөлөөс “00-ын хувьсгал”, “Нүхэн жорлон ба түүнээс гарах сөрөг үр дагаврууд”, “Ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежмент яагаад хэрэгтэй вэ?” богино хэмжээний 2D анимешнүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүргүүлж байгууллагынхаа веб сайт болон фейсбүүк хуудас, олон нийтийн сүлжээндээ байршуулж, өөрсдийн хамтран ажилладаг олон нийтийн телевизүүдээр сурталчлуулсан.



- 3.4 Зохицуулах зөвлөлийн веб сайтад 2021 онд нийтдээ 98 удаа мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулсан бөгөөд үүнд Захиргаа, удирдлагын газар-59, Үнэ тариф, судалгааны газар-26, Тусгай зөвшөөрөл, хэрэглэгчийн газар-13 удаа тус тус мэдээлэл өгсөн байна. Мөн байгууллагын фейсбүүк хуудсанд 110 удаа зурагт пост, мэдээ, мэдээлэл бэлтгэж, байршуулсан.
- 3.5 Зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь 2021 оны 03-р сарын 04-ний өдрийн SBN телевизид “Цэвэр, бохир усны төлбөр”-ийн талаар мэдээлэл өгөв.



- 3.6 Зохицуулах зөвлөлийн даргын ярилцлагыг Өдрийн сонины 2021 оны 03-р сарын 22-ны өдрийн Даваа гарагын №055 (6677) дугаарт, 2021 оны 05-р сарын 27-ны өдрийн №104(6726) дугаарт тус тус нийтлүүлсэн.
- 3.7 Зохицуулах зөвлөлийн дарга 2021 оны 03-р сарын 22-ны өдөр Үндэсний радио, С1 телевизийн мэдээний цаг болон МҮОНРТ-ын Цагийн хүрдийн мэдээнд Дэлхийн усны өдрийн талаар, 2021 оны 10-р сарын 08-ны өдөр Монгол HD, TV9, NTV, Star TV телевизүүдийн мэдээ, МҮОНРТ-ийн “Цагийн хүрд” мэдээнд ундны усны чанарын асуудлаар тус тус ярилцлага өгөв.



- 3.8 Өнөөдөр сонины 2021 оны 09-р сарын 29-ний өдрийн №189(7237) дугаарт “Өмнөговь, Хэнтий аймгийн шинэ цэвэрлэх байгууламжийн инженер, техникч, ажилтчдыг чадахуулах практик сургалт зохион байгуулсан тухай” мэдээллийг нийтлүүлсэн.
- 3.9 Зохицуулах зөвлөлөөс 2021 оны 09 сарын 30-ны өдрүүдэд “Цэвэр, бохир усны үйлчилгээ хэрэглэгч танд хэрхэн хүрдэг вэ?” “Бохир ус түүнийг хэрхэн цэвэрлэдэг вэ?”, “00-ын хувьсгал”, “Нүхэн жорлон ба түүнээс гарах сөрөг үр дагаврууд”, “Ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний тогтвортой менежмент яагаад хэрэгтэй вэ?”, “Энэ цагийн эгэл баатрууд” анимейшнүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын веб сайт болон фейсбүүк хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд хүргэсэн. Мөн 22 телевизэд хүсэлт гарган тухайн телевизүүдийн боломжтой цагуудаар тус бичлэгүүдийг цацуулж, олон нийтэд хүргэсэн.
- 3.10 Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад салбарын үйл ажиллагааг хэрэглэгчдэд сурталчилан таниулах ажлыг 2021 оны 10 дугаар сарын 01-11-ний өдрүүдэд цахим мэдээллийн хэрэгслээр 32, телевизэд өгсөн ярилцлага 28, оршин суугчдын фейсбүүк групп-т 410, байгууллагын сайтад 128, байгууллагын фейсбүүк пейж хуудаст 227, өдөр тутмын сонинд 15 удаа тус тус мэдээ, мэдээлэл өгсөн.

4

ГАДААД БОЛОН ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 4.1 Нийслэлийн ундны усны чанарын судалгаа, дүгнэлт зөвлөмж /Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Багануур, Налайх, Багахангай, Хан-Уул/ бүтээлийн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж Оюуны өмчийн газарт бүртгүүлж Зохиогчийн эрхийн гэрчилгээг авав.




- 4.2 Засгийн газраас жил бүр зохион байгуулдаг орон нутгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нартай байгуулах гэрээнд санал өгөв.
- 4.3 Азийн усны холбоотой хамтарч Усны чанарын төсөлтэй холбогдох шаардлагатай бичиг баримт, мэдээ мэдээлэл, саналыг боловсруулж хүргүүлэв. “2020 AWC Water Project”-н хүрээнд 02 дугаар сарын 28-ны өдөр эцсийн саналыг авч тус төслийг баталсан ба Азийн усны холбооны ээлжит хурлаар танилцуулагдаад байна.



4.4 Зохицуулах зөвлөлийн даргын 2021 оны 03-р сарын 09-ний өдрийн А/12 тоот тушаалаар Дэлхийн усны өдрийг тохиолдуулан орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаар тухайн аймаг, орон нутгийн харъяа ЕБС-иудын дунд ангийн сурагчдад “Усны үнэлэмж” сургалтыг явуулж, Улаанбаатар хотын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаар “Дэлхийн усны өдөр”-ыг олон нийтэд сурталчлуулах ажлыг зохион байгууллаа.



4.5 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс “Салбарын ажлын үр дүн, цаашдын зорилт” сэдэвт цахим уулзалтыг 2021 оны 04-р сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Тус цахим уулзалтад Улаанбаатар хотын ОСНААҮ-ний 82 байгууллагын 260 гаруй удирдах ажилтнуудыг хамруулав.



4.6 Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдэд бохир ус цэвэрлэх шинэ байгууламж барьж байгаатай уялдуулан эдгээр аймгийн НААҮБ-уудын “Байгууллагын хөгжил, чадавхийг сайжруулах” уулзалтыг 2021 оны 04-р сарын 05-ны өдөр цахимаар зохион байгуулав.

4.7 Азийн хөгжлийн банкны зээлээр аймгийн төвүүдэд шинээр ашиглалтад орсон ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн инженер техникчид, лабораторийн ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг төлөвлөгөөний дагуу Зохицуулах зөвлөлөөс сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтад Өмнөговь аймгийн цэвэрлэх байгууламжийн инженер, техникч, ажилчдыг 2021 оны 04-р сарны 05-



24-ний өдрүүдэд, Хэнтий аймгийн цэвэрлэх байгууламжийн инженер, техникч, ажилчдыг 2021 оны 06-р сарын 16-30 өдрүүдэд тус тус хамруулсан.

ЧИНГИС СУМЫН ШИНЭ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛҮҮ

2021.06.25

Зөвлөх инженер ЦЦАЦРАЛ

1. Цэвэрлэх байгууламжид хүлээж авах усны найрлага, тавигдах шаардлага
2. Үйлдвэр аж ахуйн нэгж байгуулалын гаргалаар дээрх бохир усны бохирдлыг тогтоож, авах арга хэмжээ
3. Цэвэрлэх байгууламжийн дамжлагууд дээрхи усны ТУ, V, DO, pH, N, P тогц

3. Цэвэрлэх байгууламжийн дамжлагууд дээрхи усны ТУ, V, DO

- Сорилгоор өнгөрч урсгалын гүрээ **EE-Lines**

Тусламж, Элэнж, Энхтүү, Аюулам

- Ургамал өсдөг усны өсгөлмөөр нэгдсэн сорилгооноос, гадаргууны цэвэрлэлтэй тус холбоотой.
- Сорилгоор сорилж, сорилж өнгөрч урсгалын гүрээг өргөжүүлж, өргөжүүлж өргөжүүлж.
- Ургамал өсдөг усны өсгөлмөөр нэгдсэн сорилгооноос, гадаргууны цэвэрлэлтэй тус холбоотой.
- Илэрхийлэл нь байгаа үед сорилгооноос өнгөрч урсгалын гүрээг өргөжүүлж, өргөжүүлж өргөжүүлж.
- Сорилгоор нэгдсэн сорилгооноос өнгөрч урсгалын гүрээг өргөжүүлж, өргөжүүлж өргөжүүлж.

4.8 Монгол Улсад Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан Барилга, хот байгуулалтын яам, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл хамтран “Нийтийн аж ахуйн салбарын цахим хурал”-ыг 2021 оны 10-р сарын 08-ны өдөр зохион байгуулав. Тус хуралд салбарын байгууллагын 230 гаруй төлөөлөгчид цахимаар оролцов.



МОНГОЛ УЛСЫН ШИНЭЛЭХ ХАМГАА ТЭНГЭЭНИЙН СӨРӨЛЖ БИЙЛЭГ, АШИГЛАЛТЫН СӨРӨЛЖ

БОХИР УС, АРИУТГАХ ТАТУУРГА ЕРӨННИЙ ОЙЛГОЛТ, БОХИР УС ЗАЙГУУЛАХ СҮЛЖЭЭ БА БАЙГУУЛАМЖ

КОНСАЛТЫН АШИГЛАЛТ, ТАТУУРГА ЕРӨННИЙН СӨРӨЛЖ БИЙЛЭГ, АШИГЛАЛТЫН СӨРӨЛЖ

Арга зүйн ойлголт


Хүснэгт 1: Гачигдлын харьцангуйн хүрээний индекс, хэмжээсээр болон насны бүтэцээр, %

	0-23 настай	25-69 настай	5-14 настай	15-17 настай	нэгд дундаар
Усан хангамж	19.6	19.9	20.3	19.7	20.1
Ариун цэвэрлэн байгууламж	70.4	69.0	71.5	71.7	70.8
Сууцны нөхцөл	76.1	74.3	77.5	76.5	76.7
МХТ-ны хүртээмж	77.5	77.3	78.3	76.1	77.7
Хяналт тасал	45.1	11.3			25.5
Баяг илэрхийлэл хүрээний индекс	69.7	68.3			71.2
Боловсрол	30.4	8.2	45.6	16.7	
Эрүүл мэнд	47.6	6.6			36.4


4.9 Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 3/716 тоот албан бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 100 хоногийн хугацаанд тус салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, Зохицуулах зөвлөлийн 2021 оны 04-р сарын 20-ний өдрийн 01/229 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлэв.





4.10 Барилга, хот байгуулалтын яамнаас 2021 оны 4 дүгээр сарын 27 өдөр зохион байгуулсан “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай хамтран “Зөв менежмент-зөв тогтолцоо” сэдэвт олон улсын чанарын болон мэдээллийн аюулгүй байдал, эрсдэл, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартууд танилцуулах цахим сургалтад Зохицуулах зөвлөлийн төлөөллийг цахимаар оролцуулав.



4.11 Мянганы сорилтын сангаас 2021 оны 04-р сарын 30-ний өдөр зохион байгуулсан Зардал нөхөх техникийн туслалцааны хүрээнд хийж буй судалгааны ажлын явцын талаарх танилцуулах цахим уулзалтад оролцов.





4.12 Зохицуулах зөвлөлөөс Үндэсний статистикийн хороотой хамтран статистикийн арга зүйн сургалтыг цахимаар зохион байгууллаа. Тус сургалтад 5 байгууллагын нийт 27 эдийн засагч болон инженер техникийн ажилтнуудыг хамруулав.



4.13 Барилга, хот байгуулалтын яамнаас 2021 оны 05-р сарын 07-ны өдөр зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлт ба жендэр”, “Барилга, хот байгуулалт ба жендэр” цахим сургалтад хамрагдав.

4.14 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран зохион байгуулсан Хүүхдийн хувьд тооцсон олон хэмжээст ядуурлын дүн шинжилгээний үр дүнг танилцуулах онлайн уулзалтад 2021 оны 06-р сарын 21-ний өдөр оролцов.



- 4.15 ШУА-тай хамтран ажиллах санамж бичгийн дагуу Ундны усны чанарын төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд:
- ✓ Сүхбаатар аймгийн ундны усны чанарын судалгааны төслийн ажлын Т/01 дүгээр гэрээг Сүхбаатар аймгийн ЗДТГ-тай байгуулж, хээрийн судалгааны ажлыг хийж, дүгнэлт, зөвлөмжийн номыг хэвлүүлэн өгөв.
 - ✓ Өмнөговь аймгийн ундны усны чанарын судалгааны төслийн ажлын Т/02 дугаар гэрээг Өмнөговь аймгийн ЗДТГ-тай байгуулж, хээрийн судалгааны ажлыг хийж, дүгнэлт, зөвлөмжийн номыг хэвлүүлэн өгөв.
 - ✓ Дундговь аймгийн ундны усны чанарын судалгааны төслийн ажлын Т/04 дугаар гэрээг Дундговь аймгийн ЗДТГ-тай байгуулж, хээрийн судалгааны ажлыг хийж, дүгнэлт, зөвлөмжийн номыг хэвлүүлэх ажлыг хийж гүйцэтгэв.
 - ✓ Сэлэнгэ аймгийн ундны усны чанарын судалгааны төслийн ажлын Т/05 дугаар гэрээг Сэлэнгэ аймгийн ЗДТГ-тай байгуулж, хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.
 - ✓ “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй төмөр зам дагуух сум, суурин газрын ундны усны чанарын судалгааны төслийн ажлын Т/06 дугаар гэрээг байгуулж, хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.
- 4.16 Үндэсний статистикийн хорооны хүсэлтийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн түгээсэн усны хэмжээг 2015-2019 оны байдлаар гаргаж хүргүүлэв.
- 4.17 БХБЯ-аас Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын хариуцаж буй инженерийн байгууламж, үйл ажиллагааны судалгааг Статистик судалгааны нэгдсэн мэдээллийг бүртгэх, ашиглах зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалын 6 болон 7-р хавсралтаар тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас судалгаа авч, нэгтгэн, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв.





- 4.18 Мянганы сорилтын сангаас зохион байгуулсан Худалдан авах чадварыг үнэлэх эдийн засгийн аргачлал сэдэвт уулзалтад 2021 оны 05-р сарын 14-ний өдрийн 15-16:30 цагийн хооронд орж, санал солилцов. Мөн 2021 оны 05-р сарын 19-ний өдрийн 9-11 цагийн хооронд төлбөр төлөх эрмэлзлийн судалгааны асуулга болон арга зүйг танилцуулах уулзалтад оролцов.
- 4.19 БХБЯ-ны “Тайшир-Алтай ус хангамж” төслийн ажлын хэсэгт Зохицуулах зөвлөлийн төлөөллийг оруулж, 2021 оны 06-р сарын 15-19-ний өдрүүдэд Говь-Алтай аймагт томилолтоор ажилласан тайлан, дүгнэлтийг гаргав.



- 4.20 БХБЯ-нд зохион байгуулагдсан Мянганы сорилтын сангийн 2 дахь компакт гэрээний дагуу хийгдсэн “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний төслийн хэлэлцүүлэгт санал, зөвлөмж өгч оролцов.




МОНГОЛЫН ИРЭГДЭМЖИЙН СООРТИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

**ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСЫГ
УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨ**



- 4.21 Хувийн хэвшлийн нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийн талаарх судалгааг шинэчлэн гаргав.

- 4.22 "Нийтийн аж ахуйн байгууллагуудын санхүү, эдийн засгийн өнөөгийн байдал, харьцуулсан судалгаа" танилцуулгын график үзүүлэлтүүдийг бэлтгэн гаргав.
- 4.23 Монгол Улсын Засгийн газрын 202 дугаар тогтоолоор батлагдсан "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг Зохицуулах зөвлөлийн 2021 оны 02-р сарын 05-ны өдрийн 01/68 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлэв.
- 4.24 "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-аас тоолуурын талаарх холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах талаар 2021 оны 04-р сарын 27-ны өдөр зохион байгуулсан онлайн хэлэлцүүлэгт оролцов.



- 4.25 Улаанбаатар хотын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төслөөс 2021 оны 05-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан "УСУГ болон ОСНААУГ-ын хооронд байгуулах гэрээг шинэчлэх" ажлын цахим хуралд санал, зөвлөмж өгч оролцов.
- 4.26 БХБЯ-нд нийслэлийн бие даасан эх үүсвэрийн өмчлөлийг тодорхойлох, нийслэлд ашиглалтыг нь шилжүүлэх ажлын үр дүн, ач холбогдлын талаар танилцуулга, мэдээллийг боловсруулан 2021 оны 05-р сарын 28-ны өдөр хүргүүлэв.
- 4.27 БХБЯ-аас ирүүлсэн "Лаг хатаах, шатаах байгууламжийн зураг төсөл боловсруулах" ажлын даалгаврыг судлан, Зохицуулах зөвлөлийн 2021 оны 06-р сарын 16-ны өдрийн 01/311 тоотоор хариуг хүргүүлэв.
- 4.28 Улаанбаатар хотын дэд бүтцийг сайжруулах төслийн хүрээнд "Хотын усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах болон байгууллагын эрх зүйн шинэчлэлтийг дэмжих" зөвлөх үйлчилгээний тайланг хэлэлцэх онлайн хуралд 2021 оны 05-р сарын 25-ны өдөр оролцов.
- 4.29 "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-аас ирсэн хүсэлтийн дагуу ХХААХҮЯ-д мал нядалгааны үйлдвэрүүдийн стандартын хэрэгжилтийг ханган ажиллуулахтай




холбоотой саналыг Зохицуулах зөвлөлийн 2021 оны 03-р сарын 07-ны өдрийн 01/67 тоот албан бичгээр хүргүүлэв.

4.30 БХБЯ болон “Усны газар”-т тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын цэвэрлэх байгууламжийн судалгааг гаргаж, Зохицуулах зөвлөлийн 2021 оны 03-р сарын 09-ний өдрийн 01/126 тоот албан бичгээр хүргүүлэв.



4.31 “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, НМХГ, СХЗГ, ОСНААМХ, ХОСНАА-н Хөгжлийн төв зэрэг байгууллагуудтай усны тоолуур баталгаажуулах асуудлаар 2021 оны 04-р сарын 27-ны өдөр уулзалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав.



4.32 Барилгын хөгжлийн төвд 2021 оны 06-р сарын 11-ний өдөр зохион байгуулсан цэвэрлэх байгууламжийн технологийн танилцуулах уулзалтад санал солилцож оролцов.

4.33 “150 мянган айлын орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн загварыг гарган БХБЯ-нд хүргүүлэв.

4.34 Нийслэлийн Прокурорын байгууллагаас 2021 оны 06-р сарын 16-ны өдөр зохион байгуулсан Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны тухай онлайн сургалтад хамрагдав.



4.35 “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388” төслийн хүрээнд Өмнөговь болон Хэнтий аймгийн шинэ цэвэрлэх байгууламжийн инженер, техникч, ажилчдыг чадавхижуулах практик сургалтыг 2021 оны 09-р сарын 26-ны өдрөөс 10-р сарын 01-ний өдрүүдэд Өвөрхангай аймгийн “Онги Ус суваг” ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулсан. Сургалтад Өмнөговь аймгийн “Гүний ус” ХХК, Хэнтий аймгийн “Хэнтий ус” ХХК-ний нийт 16 инженер, техникч, ажилчид хамрагдсан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВД БАРИГДАЖ БҮЙ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ

NC ХСУХАТҮЗЗ

ЭНГИЙН БАЙГАЛИЙН ХӨРСӨӨР ШҮҮЖ ЦЭВЭРЛЭХ АРГА

Септик → Хөрсөөр шүүх буюу хөрсөнд шингээх энгийн байгалийн биологи цэвэрлэгээ

ЗОХИОМОЛ БИОШҮҮЛТҮҮРЭЭР ЦЭВЭРЛЭХ АРГА


Септик → Биошүүлтүүрт зохиомол биологи цэвэрлэгээ →

Participants: Gunii Us HHK, Munkhzaya WSRC, Gunii Us HHK-Erunhili Inj..., Gunii us HHK Zahral, ts Chimedhoral

4.36 Шинжлэх Ухааны Академитай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнтэй хамтран “Байгалийн нөөц - Ус ашиглалт, химийн судалгаа ICCIUNR-2021” олон улсын эрдэм шинжилгээний



5-р бага хурлыг 2021 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд химийн шинжлэх ухааны 15 салбар, чиглэлийн хүрээнд цахим хэлбэрээр зохион байгуулав.



- 4.37 Монгол Улсын Ерөнхийлөгч УХүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн хамт олон нэгдэж, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд 270 гаруй мод тарив.
- 4.38 БХБЯ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс зохион байгуулсан “Монгол Улсын барилгын салбар дахь жендэрийн нөхцөл байдлын талаар хийсэн судалгааны үр дүн, гарын авлагыг танилцуулах сургалт”-д 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хамрагдав.



- 4.40 Зохицуулах зөвлөлийн харъяа Сургалт, судалгаа, мэдээллийн төвийн нээлтийн үйл ажиллагааг 2021 оны 11-р сарын 18-ны өдөр зохион байгуулав. Тус сургалтын төвийн нээлтийн үйл ажиллагаанд Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар, Зохицуулах зөвлөл, БХБЯ-ны Нийтийн аж ахуй,

инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төлөөлөл оролцов.




- 4.42 “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн ирэх 10 жилийн хугацаанд тарих мод болон цэцэрлэгжүүлэлтийн ажлын төлөвлөгөө” болон зардлын тооцоог Зохицуулах зөвлөлийн 2021 оны 11-р сарын 03-ны өдрийн 03/530 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлэв.
- 4.43 Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт-2021” эрдэм шинжилгээний хуралд 2021 оны 11-р сарын 25-ны өдөр Зохицуулах зөвлөлийн төлөөллийг оролцуулав.
- 4.44 “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Зохицуулах зөвлөлийн хариуцан гүйцэтгэх биелэлтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар гарган, БХБЯ-нд хүргүүлсэн

7

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө /мян.төг /	Гүйцэтгэл /мян.төг/	Хувь
Нийт орлогын дүн	1,323,827.60	1,376,855.30	104%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,323,827.60	1,376,435.30	104%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	420.00	100%
Хүүгийн орлого	-	-	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-	-
Нийт зарлагын дүн	1,323,827.60	1,192,778.30	90%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,384.00	736,409.90	99%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,681.80	88,713.90	89%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,534.00	72,744.00	86%
Хангамж, бараа материалын зардал	43,158.00	34,614.00	80%
Эд хогшил худалдан авах	20,000.00	13,355.00	67%
Томилолт, зочны зардал	17,542.00	4,500.00	26%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	27,631.00	21,514.70	78%
Бараа үйлчилгээний бусад зардал	244,000.00	178,480.60	73%
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,943.80	3,396.90	69%
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43,953.00	39,049.30	89%
Тоног төхөөрөмж	-	-	-





ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

🏠 “Монгол Ньюс” тауэрын 6 давхар, 8-р хороо, Их тойруу 81/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

☎ (+976) 7014-7447
🌐 <http://www.wsrc.gov.mn/>
✉ info@wsrc.mn